



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 09 сарын 09 өдөр

Дугаар 1788

Улаанбаатар хот

ГЗочид буудал, дэн буудал, амралтын газар,  
жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх  
зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан хоёр аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан зургаан аж ахуйн нэгжийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.


5. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Жуулчны баазад тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын тавдугаар хавсралтад дурдсан нэг аж ахуйн нэгжийн жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгасугай.

6. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Комо Юнайтед Инк" ХХК-ийн "Гүүд дэй" дэн буудлын 14/79 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

7. Энэхүү тушаалыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг мэргэжилтэн С.Туулд үүрэг болгосугай.


8. Зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч П.Ариунаад даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 09  
өдрийн 1/88 тоот тушаалын нэгдүгээр  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Комо Юнайтед Инк ХХК	Гүүд дэй	Баянгол дүүрэг, 8-р хороо, Дилавхутагт Жамсранжавын гудамж 14
2	Амури оргил ХХК	Гранд Хилл	Баянгол дүүрэг, 18-р хороо, Дамдинбазарын гудамж 52/1

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 20.12.09 оны 09 сарын 09  
едрийн 119 тоот тушаалын хоёрдугаар  
хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.09.

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Эко стар ХХК	Эко стар	Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 91/4
2	Алтан бумба мандал ХХК	Рич Хилл	Баянгол дүүрэг, 7-р хороо, Дилавхутагт Жамсранжавын гудамж
3	Төгөл гоо ХХК	Бурхант-2	Баянзүрх дүүрэг, 2-р хороо, Доржийн гудамж 76
4	Төгөл гоо ХХК	Бурхант-1	Баянгол дүүрэг, 22-р хороо, Зүүн Нарангийн 16090/61
5	Наранбулаг трейд ХХК	Наранбулаг	Баянгол дүүрэг, 4-р хороо, 2-р хороолол, П.Жасрайн гудамж 27а
6	Нико сервис ХХК	Намуун	Баянгол дүүрэг, 18-р хороо, Дамдинбазарын гудамж 58

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 20.09.09 оны 09 сарын 09  
өдрийн 118 тоот тушаалын гуравдугаар  
хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	ГББТ ХХК	Хаус 25	Баянгол дүүрэг, 6-р хороо, АОС-24

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2015 оны 09 сарын 09  
өдрийн 1000 тоот тушаалын дөрөвдүгээр  
хавсралт



АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2015.09.09

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Бест тур ХХК	Гурван булаг	Баянзүрх дүүрэг, 20-р хороо, Гачууртын шар хоолойн Дунд төгөл

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 20.15 оны 09 сарын 09  
өдрийн 188 тоот тушаалын тавдугаар  
хавсралт



ЖУУЛЧНЫ БААЗЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2015.09.09

Улаанбаатар хот

<i>Д/д</i>	<i>Иргэн, аж ахуйн нэгжийн нэр</i>	<i>Оноосон нэр</i>	<i>Байршил</i>
1	Сан жуулчин ХХК	Сан	Налайх дүүрэг, 6-р хороо, Өвөр Урианхайн ам

-ooOoo-